

**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН  
2025 ОНЫ “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

2026 он

## НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн хавсралт болох асуулгын үнэлгээг баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцно.
- 1.3. Компанийн нэгдсэн дүнг тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой шийдвэр гаргах, салбарын компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дүн шинжилгээ хийх, мөн компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.4. Үнэлгээний дүнг үндэслэн компанид тухайлан зөвлөмж, үүрэг, даалгаврыг хүргүүлэх ба тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлно.
- 1.5. Үнэлгээгээр эрдэлтэй гэж дүгнэгдсэн, эсхүл үнэлгээг Хороо болон бирж, мэргэжлийн холбооноос тухай бүр шаардсан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг хангалтгүй гэж тооцно.

## ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ БҮТЭЦ

- 2.1. “Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	8		80%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100%
5	Эрдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
<b>Нэгдсэн дүн</b>		<b>72</b>	<b>70</b>		<b>97%</b>

## ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

- 3.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилгоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.
- 3.2. Үнэлгээний нэдсэн дүнд үндэслэн тухай байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:
  - 3.2.1. Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
  - 3.2.2. 70-90 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
  - 3.2.3. 50-60 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
  - 3.2.4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

## ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

<b>НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>					
<b>ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.</b>					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Авсан оноо	Хувь
1.1	Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжсэн	"Инновэйшн инвестмент" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 05/03 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан. Тус журмын 2, 5, 6, 7, 8 дугаар зүйлүүдэд ТУЗ-ийн дарга, гишүүд хараат бус гишүүд, болон нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан. ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ердийн болон хараат бус гишүүдийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх сургалт зөвлөгөөг ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд тусган авч болох талаарх зохицуулалтыг 5.8, 5.9 хэсэгт тусгасан. Инновэйшн инвестмент ХК-ийн ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороод, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 2025 оны ажлын тайланг хавсаргав.	2	100%
1.2	Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3, 4 дүгээр зүйлүүдэд ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөхийг тусгасан. "Инновэйшн инвестмент" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/21 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Залгамж халааны бодлогын баримт бичиг"-ийг батлан хэрэгжүүлж ажиллаж байгаа.	2	100%
1.3	ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланг /Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу өөрийн цахим хуудсанд байршуулж Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн. Уг тайланд ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан болон ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцаа эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг тусгасан.	2	100%
1.4	Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн дэргэдэх байнгын хороод болох Аудитын хороо, Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Эрсдлийн удирдлагын хороо нь ТУЗ-өөс баталсан өөрийн холбогдох журам, зааврыг баримтлан ажилладаг. Хүйсийн тэнцвэрт байдлын хувьд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодексст заасан жендэрийн төлөөллийн доод хэмжээг хангахыг эрмэлзэн ажиллаж байна.	2	100%

1.5	ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулахдаа компанийн засаглалын сургалтанд суусан эсхийг тодорхойлж, суугаагүй гишүүдийг хамруулж, Монгол Улсын Компанийн тухай хууль, компанийн онцлогийг таниулах болон бусад сургалтыг зохион байгуулдаг. ТУЗ-ийн гишүүдэд зориулсан 2025 оны жилийн сургалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, ТУЗ-ийн бүрэлдэхүүнд зориулсан 2026 оны жилийн сургалтын төлөвлөгөөг баталсан.	2	100%
1.6	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн эрх бүхий албан тушаалтан болохын хувьд ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар бөгөөд тэрээр ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд тус журмын 8 дугаар хэсэгт ТУЗ-ийн гарийн бичгийн даргын эрх үүргийг нарийвчлан тусгасан. Инновэйшн инвестмент ХК-ийн ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороод, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 2025 оны ажлын тайланг хавсаргав.	2	100%
<b>Үнэлсэн оноо</b>				<b>12</b>	<b>100%</b>

### ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

**ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ**

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Авсан оноо	Хувь
2.1	ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т заасны дагуу болон компанийн дүрэмд заасны дагуу Одоогийн ТУЗ нь нийт 9 гишүүнтэй, ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь /3/ хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг кумуьятив аргаар сонгодог. 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар ТУЗ-ийг кумуьятив аргаар сонгох бөгөөд үүнээс 3 нь хараат бус гишүүн байна.	2	100%
2.2	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагаандаа мөрдөх үндсэн баримт бичиг болох "ТУЗ-ийн аудитын хорооны үйл ажиллагааны журам"-ыг ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/18 тоот тогтоолын хавсралт 1-ээр "Дотоод аудитын заавар"-ыг ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/23 тоот тогтоолын хавсралт 1-ээр тус тус баталсан. Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн Ш.Уянгыг сонгосон бөгөөд хуралд гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудыг хорооны гишүүдийн хүсэлтээр оролцуулдаг.	2	100%
2.3	ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин	Хэрэгжүүлэх арга хэмжээ	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагаандаа мөрдөх үндсэн баримт бичиг болох "Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам"-ыг ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/19 тоот тогтоолоор баталсан. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус ердийн эсхүл хараат бус гишүүнийг сонгодог бөгөөд хуралд гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудыг хорооны гишүүдийн хүсэлтээр оролцуулдаг. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог салгахаар төлөвлөсөн.	1	100%

	урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.				
2.4	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэрэгжүүлэх арга хэмжээ	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагаандаа мөрдөх үндсэн баримт бичиг болох "Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам" болон "Залгамж халааны бодлогын баримт бичиг" -г ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/19, 05/21 тоот тогтоолуудын хавсралтаар баталсан. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус ердийн эсхүл хараат бус гишүүнийг сонгодог бөгөөд хуралд гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудыг хорооны гишүүдийн хүсэлтээр оролцуулдаг. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог салгахаар төлөвлөсөн.	1	100%
2.5	ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн ТУЗ нь "Аудитын хороо", "Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо", "Эрсдэлийн удирдлагын хороо" гэсэн 3 байнгын болон "Стратеги хөгжлийн хороо"-г байгуулан ажиллаж байна. "Комплайнсын хяналтын заавар" болон "Эрсдэлийн удирдлагын заавар"-ыг ТУЗ-ийн хурлаар батлуулсан. Хороодын гишүүд, даргыг сонгохдоо мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг нь үндэслэсэн.	2	100%
<b>Үнэлсэн оноо</b>				<b>8</b>	<b>80%</b>
<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>					
<b>ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана</b>					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Авсан оноо	Хувь
3.1	ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт гавина.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудад компанийн талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу ил тод тайлагнан, мэдээлэх зорилгоор "Мэдээллийн үйл ажиллагааны журам"-ыг ТУЗ-ийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/17 тоот тогтоолын хавсралт 1-р баталсныг хэрэгжүүлэн ажиллаж байна.	2	100%

3.2	ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжсэн	<p>Компанийн үйл ажиллагааг хувьцаа эзэмшигчдэд ил тодоор явуулах үүднээс дараах дүрэм, журам, баримт бичиг, төлөвлөгөөг батлан тухай бүр өөрийн царим хуудсын "Хөрөнгө оруулагч" цэсэнд байршуулан ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• <a href="#">Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">Ногдол ашгийн бодлого</a></li> <li>• <a href="#">Ёс зүйн дүрэм</a></li> <li>• <a href="#">Мэдээллийн үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хорооны үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам</a></li> <li>• <a href="#">Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхолын зөрчлийг зохицуулах журам</a></li> <li>• <a href="#">Залгамж халааны бодлогын баримт бичиг</a></li> <li>• <a href="#">Шүгэл үлээх бодлого</a></li> <li>• <a href="#">Хувьцаат компанийн дотоод аудитын заавар</a></li> <li>• <a href="#">Эрсдэлийн удирдлагын заавар</a></li> <li>• <a href="#">Комплайнсын хяналтын заавар</a></li> <li>• <a href="#">Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудтай харилцах хөтөлбөр</a></li> </ul>	2	100%
3.3	Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн санхүү, татварын тайлан, тодруулгуудыг холбогдох хууль, тогтоомж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, зохицуулагч байгууллагын журам, зааварт нийцүүлсэн үнэн зөв, материаллаг алдаагүй бэлтгэн, 2025 оны санхүүгийн тайланг олон улсын нэр хүнд бүхий Мүүр аудитын байгууллагаар баталгаажуулан тогтоосон цаг хугацаанд багтаан олон нийтэд ил тод тайлагнасан. Мөн санхүүгийн бус тайлан буюу үйл ажиллагааны тайланг тогтмол бэлтгэн олон нийтэд ил тод өөрийн цахим хуудаст байршуулдаг. <a href="#">2025 оны жилийн үйл ажиллагааны тайлангийн санхүүгийн бус мэдээлэлд хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээллийг тусгасан.</a>	2	100%
<b>Үнэлсэн оноо</b>				<b>6</b>	<b>100%</b>
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>					
<b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</b>					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Авсан оноо	Хувь
4.1	ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар	Бүрэн хэрэгжсэн	<p>Аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар заасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөндлөнгийн аудитор сонгох талаар зөвлөмж гаргах ба үүнд аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдал, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл, аудиторын хөлс зэргийг багтаана.</li> <li>• Хөндлөнгийн аудиторын ажлыг жилийн эцэст үнэлж дүгнэх, хувьцаа эзэмшигчдийн хуралд хөндлөнгийн аудиторын томилгоо, дахин томилох, эсвэл гэрээг цуцлах асуудлаар мэдээлэл</li> </ul>	2	100%

	тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.		<p>зөвлөмж бэлтгэх ба хөндлөнгийн аудитын томилгоотой холбогдуулан хөндлөнгийн аудитын дүгнэсэн, сонгон шалгаруулсан байдлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>Хөндлөнгийн аудитортой хамтран тухайн жилийн аудитын ажлын хүрээ, төлөвлөгөө, аудитын дагаж мөрдөх дотоод дүрмийг батлах бөгөөд ингэхдээ компанийн тухайн үеийн нөхцөл байдал, хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг болон тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг харгалзан үзэх ба мөн хөндлөнгийн аудитортой байгуулах гэрээний төслийг боловсруулна.</li> <li>Аудиторын хэвийн үйл ажиллагаанд саад бэрхшээл гарахад түүнийг шийдвэрлэх ба үүнд аудит хийх ажлын хүрээнд ямар нэг хязгаарлалт тавих эсвэл мэдээлэлд чөлөөтэй нэвтрэх боломжийг хязгаарлах зэрэг асуудал багтана.</li> <li>Хөндлөнгийн аудиторын шалгалтын явцад илэрсэн зөрчил, түүний гаргасан зөвлөмж болон гүйцэтгэх удирдлагын зүгээс тухайн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаар хэлэлцэнэ.</li> <li>Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр гарах асуулт, тодруулгад хариу өгөх нөхцөлөөр хөндлөнгийн аудиторыг хангана.</li> <li>Компанийн санхүүгийн тайланг компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, практикийн дагуу боловсруулах нөхцлийг хангана.</li> <li>Хөндлөнгийн аудиторууд, түүн дотор компанитай тэргүүн ээлжид ажилладаг аудитын компанийн хараат бус байдлыг хангана.</li> </ul>		
4.2	Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжсэн	Аудитын хорооны үйл ажиллагааны журмын 2.1.3.6 дахь хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр гарах асуулт, тодруулгад хариу өгөх нөхцөлөөр хөндлөнгийн аудиторыг хангана" гэж заасан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хөндлөнгийн аудиторын дүгнэлтийг бүрэн эхээр нь танилцуулж, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл авах эрхийг ханган ажилладаг.	2	100%
4.3	Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн бүтцийн талаарх мэдээллийг 2025 оны жилийн тайланд тусгаж, түүнийг Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу өөрийн болон Биржийн цахим хуудаст байршуулсан. <a href="https://i-investment.mn/">https://i-investment.mn/</a> Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороод Дотоод аудитын үүргийг гүйцэтгэн ажилладаг.	2	100%
<b>Үнэлсэн оноо</b>				<b>6</b>	<b>100%</b>
<b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>					
<b>ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</b>					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Авсан оноо	Хувь
5.1	Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн ТУЗ-өөс "Эрсдэлийн удирдлагын заавар"-г баталж Эрсдэлийн удирдлагын хороог 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.	2	100%

5.2	ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь 3 гишүүнээс бүрдэнэ. Хорооны гишүүдийн гуравны хоёр буюу 2 гишүүн нь хараат бус гишүүн бөгөөд хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, ердийн гишүүн болно.	2	100%
5.3	Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн үйл ажиллагааны тайланд нийгмийн хариуцлагын талаар тусгасан бөгөөд БОНЗ-ийн тайланг анх удаа сайн дураар бэлтгэн Биржийн цахим хуудаст нээлттэй байршуулсан.	2	100%
5.4	Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн ТУЗ-өөс Комплайнсын хяналтын заавар"-г баталж, Комплайнсын ажилтны чиг үүргийг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүд хариуцан ажилладаг.	2	100%

**Үнэлсэн оноо**

**8 100%**

**ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ**

**Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна**

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Авсан оноо	Хувь
6.1	ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжсэн	2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ХЭХ-аар ТУЗ-ийн гишүүдийн нөхөн олгох болон ирэх жилүүдийн цалингийн төсвийг баталсан.	2	100%
6.2	Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн 2024 оны 08 сарын 01-ний өдрийн 05/10 дугаар тогтоолоор "Гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох журам"-ыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.	2	100%

	шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.				
6.3	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Бүрэн хэрэгжсэн	2025 оны жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ болон удирдлагын багийн цалин урамшууллын хэмжээг тусгасан.	2	50%

**Үнэлсэн оноо**

**6 100%**

**ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ**

**Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ**

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Авсан оноо	Хувь
7.1	Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, гэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/26 тоот тогтоолоор "Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудтай харилцах хөтөлбөр"-ийг баталсан.	2	100%
7.2	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжсэн	2025 онд хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудтай харилцах харилцааг сайжруулахаар дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: Компанийн цахим хуудсыг шинэчилсэн, Хөрөнгө оруулагчидтай харилцах харилцааг сайжруулах 1 жилийн хугацаатай зөвлөх үйлчилгээг СММ-с авч ажилласан. Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчидтэй харилцах чиг үүрэгтэй Хөрөнгө оруулагчийн харилцаа хариуцсан менежер ажилладаг.	2	100%
7.3	Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн цахим хуудас болон сошиал хаяг, мэйл хаягийг үр дүнтэйгээр ажиллуулж байна. <a href="https://www.i-investment.mn/">https://www.i-investment.mn/</a>	2	100%
7.4	Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх,	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/22 тоот тогтоолоор "Шүгэл үлээх бодлого"-ыг баталсан. Ажилтнуудын санал хүсэлт, гомдол хүлээн авч шийдвэрлэх журам-ыг 2024 оны 12 дугаар сард гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан.	2	100%

мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.				
--	--	--	--	--

**Үнэлсэн оноо**

**8**

**100%**

**НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ**

**ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно**

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Авсан оноо	Хувь
8.1	Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/16 тоот тогтоолоор "Ёс зүйн дүрэм"-ийг баталж компанийн веб хуудаст байршуулж олон нийтэд мэдээлсэн.	2	100%
8.2	Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/22 тоот тогтоолоор "Шүгэл үлээх бодлого"-ыг баталсан.	2	100%
8.3	Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжсэн	Ёс зүйн дүрэмд ТУЗ-ийн гишүүн болон ажилтан нь авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх, улс төрийн үйл ажиллагааг дэмжихгүй, хандив өгөхөөс зайлсхийн төвийг сахисан байр суурьтай байх талаар зохицуулсан.	2	100%

**Үнэлсэн оноо**

**6**

**100%**

**ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ**

**Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана**

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Авсан оноо	Хувь
---	------	-----------	---------	------------	------

9.1	Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжсэн	Компани 2025 онд <a href="https://www.i-investment.mn">https://www.i-investment.mn</a> /цахим хуудсаа шинэчилсэн бөгөөд хөрөнгө оруулагчид цэсээр дамжуулан үйл ажиллагааны болон санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг тогтмол мэдээллэн ажилладаг.	2	100%
9.2	Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/26 тоот тогтоолоор "Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудтай харилцах хөтөлбөр"-ийг баталсан.	2	100%
9.3	Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх зэрэг хууль ёсны эрхийг хамгаалан зохицуулсан. Энэ хүрээнд холбогдох хууль тогтоомж, дотоод дүрэм, журмын дагуу ажиллаж байна. 2025 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлыг тайлант хугацаанд зохион байгуулсан.	2	100%
9.4	Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжсэн	Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор баталахаар заасан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Компанийн дүрэмд нэмэлт, өөрлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах</li> <li>• Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах</li> <li>• Компанийн хэлбэрийг өөрчлөх</li> <li>• Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох</li> <li>• Давуу эрхийн хувьцаа гаргах</li> <li>• Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох</li> <li>• Хувьцааг хуваах буюу нэгтгэх</li> <li>• Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх эсэх</li> </ul>	2	100%
9.5	Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/20 тоот тогтоолоор "Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхолын зөрчлийг зохицуулах журам"-ыг баталсан. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/-т тусгаж олон нийтэд мэдээлсэн.	2	100%
<b>Үнэлсэн оноо</b>				<b>10</b>	<b>100%</b>
<b>Нэгдсэн оноо</b>				<b>70</b>	<b>97%</b>

## НОТЛОХ БАРИМТЫН ЖАГСААЛТ

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
2. Нөгдол ашгийн бодлого
3. Ёс зүйн дүрэм
4. Мэдээллийн үйл ажиллагааны журам
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хорооны үйл ажиллагааны журам
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
7. Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхолын зөрчлийг зохицуулах журам
8. Залгамж халааны бодлогын баримт бичиг
9. Шүгэл үлээх бодлого
10. Хувьцаат компанийн дотоод аудитын заавар
11. Эрсдэлийн удирдлагын заавар
12. Комплайнсын хяналтын заавар
13. Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудтай харилцах хөтөлбөр
14. 2025 оны жилийн үйл ажиллагааны тайлан